



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2018 оны 11 сарын 27 өдөр

Дугаар А/439

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Дээд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалт, МУИС-ийн Дүрмийн 4.3.1, 4.3.8.4, захиргааны зөвлөлийн 2018 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."МУИС-ийн судалгааны ажлын санхүүжилтийн журам"-ын шинэчилсэн найруулгыг 1 дүгээр хавсралтаар, МУИС-ийн судалгааны төсөл, тэтгэлгийн санхүүжилтийн хэмжээг 2 дугаар хавсралтаар тус тус баталж, 2018 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2.Энэ тушаал гарсантай холбогдуулан МУИС-ийн захирлын 2016 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн А/52 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа хариуцсан дэд захирал (Б.Очирхуяг), Хөгжил, санхүү хариуцсан дэд захирал (Ч.Ундрэм), Сургалт, оюутан хариуцсан дэд захирал (Б.Очирхуяг) болон бүрэлдэхүүн сургуулийн захирал нарт үүрэг болгосугай.


ЗАХИРЛЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Я.ТӨМӨРБААТАР

My document.Tushaal.2018

20184062



Захирлын 2018 оны 11 дүгээр сарын
27-ны өдрийн 41 дугаар тушаалын
хавсралт

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН СУДАЛГААНЫ САНХҮҮЖИЛТИЙН ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. МУИС 2016-2024 оны стратегийн төлөвлөгөөндөө “Судалгааны хамрах хүрээг өргөжүүлэх, судалгааны түвшинг дэлхийн жишигт нийцүүлэх”-ээр тэргүүлэх чиглэлээ тодорхойлж, судалгааны их сургууль болон хөгжих зорилт тавин ажиллаж буйтай холбогдуулан судлаач багш нарын судалгааны үйл ажиллагааг дэмжих, эрдэм шинжилгээний бүтээлийн түвшин, эрдэм шинжилгээний гадаад, дотоод хамтын ажиллагааг нэмэгдүүлэх харилцааг зохицуулахад энэхүү журмын (цаашид “журам” гэх) зорилго оршино.

1.2. Судалгааны санхүүжилтийг профессор багш нарт болон докторын зэрэгтэй залуу багш нарт суурь зардал хэлбэрээр олгох, салбар дамнасан судалгаа хийх залуу судлаачдын багт тэтгэлэг олгох, МУИС-ийн профессор багш нартай хамтарсан судалгаа хийж, үр дүнгээ нийтлүүлэх судлаачдад судалгааны тэтгэлэг олгох (fellowship institute), өндөр түвшний судалгааны үр дүнг нийгэм, эдийн засгийн эргэлтэнд оруулах, өртөг хуваалцах, инновацийг дэмжих зэрэг үйл ажиллагаанд зарцуулна. МУИС-ийн бүрэлдэхүүн/салбар сургууль санхүүжүүлдэг дотоод төслүүдийг сонгон шалгаруулж, хэрэгжүүлэхэд энэхүү журмыг мөрдөг болно.

1.3. МУИС нь дараах судалгааны төсөл, тэтгэлэгийг санхүүжүүлнэ. Үүнд:

- Судалгааны суурь зардал
- Залуу судлаачдын багийн тэтгэлэг
- Зочин судлаач, докторын дараах судалгааны тэтгэлэг
- Өндөр түвшний судалгааны төсөл

- Өртөг хуваалцах хамтарсан төсөл
- Инновацийн төсөл



1.4. МУИС-иас санхүүжиж байгаа судалгааны төсөл, тэтгэлэг, суурь зардлын хэмжээг МУИС-ийн захиргааны зөвлөлөөс тогтооно.

1.5. Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно.

1.5.1. “Суурь судалгааны зардал” гэж МУИС-д профессор, дэд профессор болон ахлах багшийн зэрэглэлд ажиллаж байгаа докторын зэрэгтэй үндсэн орон тооны багш нарын судалгааны үйл ажиллагааг дэмжих зорилгоор олгох зардлыг хэлнэ.

1.5.2. “Залуу судлаачдын багийн тэтгэлэг” гэж салбар дундын хамтын ажиллагаа, хамтарсан судалгааг дэмжих, нээлттэй, дундын ашиглалттай дэд бүтцийг бүрдүүлэх, судалгааны ажил хийх дадал төлөвшүүлэх зорилгоор докторын зэрэгтэй багшид олгох тэтгэлгийг хэлнэ.

1.5.3. “Зочин судлаачийн тэтгэлэг” гэж МУИС-ийн үндсэн профессор багш нарын судалгааны чиглэлээр гэрээ байгуулж МУИС-д 6 хүртэл сарын хугацаагаар гадаадын их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагаас ирж, хамтран ажиллах профессорын (докторын дараах судалгааны ажлыг хамруулж болно) судалгааны ажлын санхүүжилтийг хэлнэ.


1.5.4. “Өндөр түвшний судалгааны төсөл” гэж судалгааны ажлын үр дүнг Journal Citation Reports (JCR)-ын импакт фактор бүхий олон улсын мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлэх зорилго бүхий үндсэн орон тооны профессор, дэд профессорын дэвшүүлсэн төслийг хэлнэ.

1.5.5. “Өртөг хуваалцах хамтарсан төсөл” гэж нэг талаас МУИС нөгөө талаас гадаад, дотоодын судалгааны сан, их дээд сургууль, аж үйлдвэрийн байгууллага, төрийн бус байгууллагууд хамтран судалгааны санхүүжилтийн зардлыг хамтран босгож хэрэгжүүлэх төслийг хэлнэ.

1.5.6. “Инновацийн төсөл” гэж патентын мэдүүлэг эсхүл патентыг үндэслэн аж үйлдвэрийн компанитай байгуулах лицензийн гэрээ, гарааны компани бойжуулах эсхүл нийгмийн инновацийн (нийгэмд шинэ хууль, бодлого, хөтөлбөр нэвтрүүлэх) үйл ажиллагааг санхүүжүүлэх төслийг хэлнэ.

1.6. Бүх хэлбэрийн төслийн саналыг өрсөлдөөний зарчмаар шалгаруулж,

гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэх, санхүүжүүлэх бөгөөд өндөр түвшний судалгааны ангиллаар санхүүжүүлэх төслийн тоо нь байгалийн ухаан, инженер технологи, нийгмийн ухаан, хүмүүнлэгийн ухааны салбаруудад жигд байх зарчмыг баримтална.



ХОЁР. ПРОФЕССОР, ДЭД ПРОФЕССОР, ДОКТОР БАГШ НАРТ
СУДАЛГААНЫ ЗАРДАЛ ОЛГОХ

2.1.МУИС-д профессорын зэрэглэлд болон дэд профессорын зэрэглэлд ажиллаж буй багшид судалгааны суурь зардал олгоно.

2.2.Ахлах багшийн зэрэглэлд ажиллаж буй, докторын зэргээ 5 хүртэл жилийн өмнө хамгаалсан багшид судалгааны суурь зардал олгох бөгөөд зардал олгох санхүүгийн жилээс календарийн таван жилийн өмнөх оны 01-р сарын 01-нээр 5 жилийн хугацааг тасалбар болгон тооцно.

2.3.Дээрх санхүүжилтийг судалгааны дараах төрлийн зардалд зарцуулна.

Үүнд:

- Олон улсын мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх,
- Ном, сурах бичиг, гарын авлага хэвлүүлэх,
- Багаж төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилготой бүрдэл хэсэг, эд анги, материал, мэргэжлийн ном, сэтгүүл өгүүлэл, программ хангамж худалдан авах,
- Зочин судлаач хүлээж авах зардал,
- Оюутанд ажлын хөлс, тэтгэлэг олгох,
- Лабораторийн судалгаанд зарцуулах,
- Хээрийн судалгаанд зарцуулах,
- Олон улсын хуралд оролцох, семинар, симпозиум зохион байгуулах, хурал, семинар, симпозиумд оролцох судлаачийг гадаадаас урьж ирүүлэх.

2.4.Суурь зардлыг профессор, багшийн цалин, ажлын хөлсөнд зарцуулахыг хориглоно.

2.5. Профессор, дэд профессор, ахлах багшийн зэрэглэлд ажиллаж буй докторын зэрэгтэй багш нар судалгааны суурь зардал авах төслийн саналаа хавсаргасан загварыг (Хүснэгт 1) ашиглан бичиж, зохих баримтуудыг хавсарган тэнхмийн эрхлэгчээрээ дамжуулан жил бүрийн зарласан хугацаанд багтаан бүрэлдэхүүн сургууль, салбарын захиргаанд ирүүлнэ.

ГУРАВ. ЗАЛУУ СУДЛААЧДЫН БАГТ ТЭТГЭЛЭГ ОЛГОХ

3.1.Тэтгэлгийг 45 хүртэлх насны, 3-аас цөөнгүй залуу судлаачдаас бүрдсэн багт (ялгаатай ШУ-ны салбараас баг бүрдүүлсэн тохиолдолд давуу талтай) санхүүжилт олгоно. Судалгааны багийн ахлагч нь докторын зэрэгтэй байх бөгөөд гишүүд нь докторын зэргээ хамгаалаагүй байж болно. Монгол судлалтай холбоотой залуу судлаачдын судалгааны ажлыг онцгойлон дэмжих бодлого баримтална.

3.2.Санхүүжилтийг цалин, ажлын хөлсөнд зарцуулахыг хориглох бөгөөд дараах зүйлд зарцуулахыг зөвшөөрнө. Үүнд:

- Олон улсын мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх,
- Багаж төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилготой бүрдэл хэсэг, эд анги, материал, мэргэжлийн ном, сэтгүүл өгүүлэл, программ хангамж худалдан авах,
- Оюутанд ажлын хөлс, тэтгэлэг олгох (судалгааны туслах байдлаар удаан хугацаанд тогтвортой ажиллуулахыг илүү дэмжинэ),
- Лабораторийн судалгаанд зарцуулах,
- Хээрийн судалгаанд зарцуулах.

3.3.Санхүүжилтийг судалгааны салбар дундын шинж чанар, судалгааны нээлттэй, дундын ашиглалттай дэд бүтцийг бүрдүүлэх боломж, доктор, докторын дараах судалгааны ажлаа үр дүнд хүргэх баталгаа, багийн гишүүдийн

судалгааны ажлын туршлага, судалгааны ажлын үр дүнгээр JCR импакт фактор бүхий олон улсын сэтгүүлд (нийгэм, хүмүүнлэгийн салбарт Scopus цахим сангийн SCImago Journal Ranking (SCR), Source Normalized Impact per Paper (SNIP) индекстэй сэтгүүл байж болно) өгүүлэл хэвлүүлэх, оюуны өмч бий болгох боломж, хамтарсан судалгаа, семинараар дамжуулан өөр шинжлэх ухаан, технологийн салбарын залуу эрдэмтэд, оюутнуудын хоорондын хамтын ажиллагаа гүнзгийрч, цаашид цогц судалгааг тогтмол хийх соёлыг төлөвшүүлэх, баг бүрдэх байдал зэргийг харгалзан олгоно.

3.4.Залуу судлаачдын баг төслийн санал дэвшүүлэх бөгөөд хүлээгдэж буй үр дүнгээ 1 жилийн хугацаагаар тооцож тодорхой тусгах шаардлагатай бөгөөд нийгэм, хүмүүнлэгийн салбарын судлаачдын төсөл хэрэгжүүлэх хугацааг гэрээнд тусгах байдлаар хугацааны дэмжлэг үзүүлж болно.

3.5.Залуу судлаачдын багт тэтгэлэг олгох төслийн саналыг жил бүр зарласан хугацаанд хавсаргасан загварыг (Хүснэгт 2) ашиглан бичиж төслийн мэдээллийн менежментийн систем (ТММС)-д цахим хэлбэрээр хүлээлгэн өгнө.

ДӨРӨВ. ЗОЧИН СУДЛААЧ, ДОКТОРЫН ДАРААХ СУДАЛГААНЫ ТЭТГЭЛЭГ (FELLOWSHIP) ОЛГОХ

4.1. Зочин судлаач, докторын дараах тэтгэлгийн санхүүжилтэд Монголтой холбоотой судалгаа хийдэг гадаадын иргэд ба гадаад орны их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад ажилладаг Монгол Улсын иргэд хамрагдах эрхтэй.

4.2. Зочин, докторын дараах судлаачийн тэтгэлгийн санхүүжилтийг түүнтэй хамтран ажиллах МУИС-ийн профессор багштай хийсэн гэрээгээр зохицуулж, дараах хэлбэрээр зарцуулна. Үүнд:

- Зочин, докторын дараах судлаачийн Монгол Улсад ирэх замын зардал,
- Монгол Улсад судалгаа хийх судалгааны зардал,
- Олон улсын мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх,
- Зочин, докторын дараах судлаачийн тэтгэлэг (стипендийн хэмжээг

судлаачийн судалгааны ажлын туршлага, өөрсдийнх нь санал болгож буй хэмжээ болон холбогдох бусад хүчин зүйлийг харгалзан харилцан зөвшилцөх замаар тогтооно).

4.3.Энэхүү санхүүжилтээр зочин, докторын дараах судлаачидтай хамтран ажиллах МУИС-ийн профессор багшид нэмэгдэл цалин хөлс олгохгүй.

4.4.Зочин, докторын дараах судлаачийн судалгааны ажлын туршлага, мэдлэгийг МУИС-ийн эрдмийн хамт олонд хүртээмжтэй байх зорилгоор МУИС-ийн хичээл явагдаж байх хугацаанд ирүүлж ажиллуулахыг чухалчилна.

4.5.Төсөл нь доорх шаардлагыг хангасан байна. Үүнд:

4.5.1.JCR импакт фактор бүхий олон улсын сэтгүүлд МУИС-ийн профессор багштай хамтран бичсэн өгүүлэл хэвлүүлэх (хэвлэхээр зөвшөөрөгдсөн (accepted) өгүүллийг үр дүнд тооцож болно),

4.5.2.Судлаач нь судалгааны ажлын үр дүнгээ МУИС-ийн эрдмийн хамт олонд илтгэж танилцуулах,

4.5.3.Судалгааныхаа чиглэлээр багш, суралцагсдад семинар явуулах, зөвлөгөө өгөх.

4.6.Зочин, докторын дараах судлаач авч ажиллуулах санал хүлээн авах тухай зарлах ажлыг Эрдэм шинжилгээний хэлтэс (ЭШХ)-ээс олон улсын хэмжээнд зохион байгуулна. Зочин, докторын дараах судлаач нь төслийн саналаа англи, эсвэл монгол хэлээр бичиж, жил бүр зарласан хугацаанд хавсаргасан загварыг (Хүснэгт 3) ашиглан бичиж ТММС-д цахим хэлбэрээр хүлээлгэн өгнө.

4.7.Үнэлгээний ажлын хэсэг зочин судлаачийн ирүүлсэн төслийн саналд үнэлгээ хийхдээ доорх гол шалгуур үзүүлэлтийг харгалзана. Үүнд:

4.7.1.Судлаачийн судалгааны ажлаа хэвлүүлсэн байдал,

4.7.2.Зочин, докторын дараах судлаачтай хамтран ажиллах МУИС-ийн профессорын судалгааны ажлаа хэвлүүлсэн байдал,

4.7.3.Зочин, докторын дараах судлаачийн санал болгож буй судалгааны төслийн хэрэгжих боломж, ажлын төлөвлөгөө, үр дүнгийн баталгаа,

4.7.4.МУИС-ийн багш, суралцагчидтай хамтран ажиллах, чадавхжуулах

байдал,
4.7.5.Эрдэм шинжилгээний хамтын ажиллагааг цаашид тогтвортой
үргэлжлүүлэх төлөвлөгөө.



ТАВ. ӨНДӨР ТҮВШНИЙ СУДАЛГААНЫ ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТ ОЛГОХ

5.1. Өндөр түвшний судалгааны үр дүнд JCR импакт фактор бүхий олон улсын сэтгүүлд нэгдүгээр болон холбоо барих зохиогчоор нэгээс доошгүй, хамтран зохиогчоор хоёроос доошгүй өгүүлэл хэвлүүлнэ (хэвлэхээр зөвшөөрөгдсөн (accepted) өгүүлэл, МУИС-ийн нэр дээр мэдүүлсэн оюуны өмчийн эрхийн хамгаалалтыг үр дүнд тооцож болно).


5.2. Өндөр түвшний төслийн зардлыг доор заасан хэлбэрээр зарцуулна. (цалин, ажлын хөлсөнд зарцуулахыг хориглоно). Үүнд:

- Олон улсын мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх,
- Багаж төхөөрөмж, түүний хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилготой бүрдэл хэсэг, эд анги, материал, мэргэжлийн ном, сэтгүүл өгүүлэл, программ хангамж худалдан авах,
- Оюутан, докторын дараах судлаачид ажлын хөлс, тэтгэлэг олгох (судалгааны туслах байдлаар удаан хугацаанд тогтвортой ажиллуулахыг илүү дэмжинэ),
- Лабораторийн судалгаанд зарцуулах,
- Хээрийн судалгаанд зарцуулах.

5.3. Профессор багш, судлаачид өндөр түвшний судалгааны төслийн санал дэвшүүлэх бөгөөд хүлээгдэж буй үр дүнгээ 1 жилийн хугацаагаар тооцож тодорхой тусгах шаардлагатай.

5.4. Өндөр түвшний төслийн саналыг хавсаргасан загварыг (Хүснэгт 4) ашиглан бичиж, жил бүр зарласан хугацаанд ТММС-д цахим хэлбэрээр хүлээлгэн өгнө.

ЗУРГАА. СУДАЛГААНЫ ӨРТӨГ ХУВААЛЦАХАД ОЛГОХ ЗАРДАЛ



6.1. Өртөг хуваалцах төсөл (ӨХТ)-ийн саналыг МУИС-ийн үндсэн орон тооны профессор, дэд профессор, багш нар бүрэлдэхүүн сургуулийн салбарын эрдмийн зөвлөлөөс дэмжлэг авсаны үндсэн дээр хэрэгжүүлэх эрхтэй болно.

6.2. ӨХТ-ийн гэрээг Санхүү, төлөвлөлт хариуцсан (СТХ) дэд захирал төслийг хэрэгжүүлэгч профессор, дэд профессор багш өртөг хуваалцагч байгууллагын төлөөлөл хамтарч байгуулна.

6.3. Өртөг хуваалцах дэмжлэг хүсэхдээ дараах зүйлийг тодорхой тусгасан байна. Үүнд:

6.3.1. Санхүүжүүлэгч байгууллага, судалгааны сан, гадаадын их сургууль, аж үйлдвэр, компани, төрийн бус байгууллага (ТББ) нь хамтарсан судалгаа хийх сонирхлоо илэрхийлсэн захидал,

6.3.2. Санхүүжүүлэгч байгууллагаас төслийн санал хүлээн авах тухай зар,


6.3.3. Санхүүжүүлэгч байгууллага, судалгааны сан, гадаадын их сургууль, аж үйлдвэр, компанид өгөх өртөг хуваалцах санхүүжилтийн төсөв,

6.3.4. Төсөлд оролцох багийн гишүүдийн сүүлийн таван жилийн олон улсын чанартай бүтээлийн жагсаалт

6.4. Өртөг хуваалцах хамтарсан төсөлд МУИС нийт төсвийн 30 хүртэлх хувийг санхүүжүүлнэ. Хамтарсан төслийн өртөг хуваалцахад дэмжлэг өгөх саналд доорх зардлыг оруулна. Үүнд:

- Гадаад, дотоодын томилолтын зардал
- Гадаад профессорын Монгол Улсад нэг долоо хоног ба түүнээс доош хугацааны дотоод зардал
- Нарийн мэдрэмжтэй судалгааны багаж төхөөрөмжийн үнэ ба гаалийн татвар
- Багаж төхөөрөмжийн суурьлуулалтын зардал
- Дундын багаж төхөөрөмж ашигласан зардал

- Гадны байгууллагын лабораториор гүйцэтгүүлэх урьдчилсан шинжилгээний төлбөр
- Гадаад, дотоодын мэргэжлийн байгууллага, яам, агентлагаас авах зөвшөөрлийн төлбөр
- Бичиг хэргийн зардал



6.5. Өртөг хуваалцах төслийн саналыг хавсаргасан загварыг (Хүснэгт 5) ашиглан бичиж зарласан хугацаанд ЭШХ-т цахим хэлбэрээр хүлээлгэн өгнө.

6.6. Хамтарсан судалгааны үйл ажиллагааны үр дүнд хөрөнгө оруулалтаар орж ирсэн багаж техникийн, урвалж, бодис, материалын үнэлгээний комиссоор орсон дүгнэлт, МУИС-ийн дансаар орж ирсэн санхүүгийн баримт, төсвийн зарцуулалтын тайлангийн хамт ЭШХ-т хүргүүлнэ.

ДОЛОО. ИННОВАЦИЙН ТӨСӨЛ

7.1. МУИС-ийн үндсэн орон тооны профессор, дэд профессор, докторын зэрэгтэй багш нар бүрэлдэхүүн сургуулийн эрдмийн зөвлөлөөс дэмжлэг авсны үндсэн дээр төслийг зарласан хугацаанд Инноваци, технологи дамжуулах төв (ИТДТ)-д цахим (Хүснэгт 6) ирүүлнэ.

7.2. Инновацийн төсөл хэрэгжүүлэхэд дараах шаардлагын аль нэгийг биелүүлсэн байна. Үүнд:

7.2.1 Технологид суурилсан төслийн хувьд төслийн удирдагч нь батлагдсан эсвэл мэдүүлсэн оюуны өмчийн зохиогч байх, тус оюуны өмчийг МУИС эзэмшдэг байх.

7.2.2 Нийгмийн инноваци, гарааны компанийн үйл ажиллагааг хөгжүүлэх чиглэл бүхий төслийн хувьд төслийн багийн гишүүдийн сүүлийн таван жилийн хугацаанд хийж гүйцэтгэсэн бүтээлийн жагсаалт ба төсөл гаргах.

7.3. Инновацийн төслийг хэрэгжүүлэхэд Инновацийн тухай хууль, МУИС-ийн Оюуны өмчийн талаар баримтлах бодлого, МУИС-ийн Технологи дамжуулах журамд нийцүүлэн хамтрагч байгууллагаас дэмжлэг үзүүлэх хэлбэр, хамтран ажиллах зарчмыг тодорхойлж гэрээ байгуулсан байна.

1117144746
УХД0072 9104399

7.4. Төслийн хэрэгжилтэд шинжлэх ухааны салбарын мэргэжлийн эрдэмтэд, судлаачид, ахисан түвшний оюутнуудын хамтын оролцоо болон лаборатори, багаж тоног төхөөрөмж, туршилтын бааз бүрдүүлсэн байна

7.5. Төсөл хэрэгжүүлэгч нь хагас жил тутам нэг удаа төслийн явц болон хэрэгжилтийн хүрээнд төслийн хамтрагч талуудын оролцоог бүрдүүлж танилцуулга уулзалт, хурал эсвэл зөвлөгөөнийг зохион байгуулсан байна.

7.6. Инновацийн төслийн хэрэгжилтийн үйл ажиллагаанд ИТДТ хяналт тавина.

7.7. Инновацийн төслийн үр дүнд гарааны компани, технологийн лицензийн гэрээ байгуулагдсан, нийгмийн инновацийн шийдэл нь хэрэглээнд нэвтэрсэн байна.

НАЙМ. ТӨСЛИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ, ТАЙЛАН

8.1. МУИС-иас санхүүжих судалгааны төсөл, тэтгэлэгт хөтөлбөрүүдийг хичээлийн шинэ жилийн эхний сард зарлаж (9 дүгээр сарын 1-нээс 10 дугаар сарын 1-ний өдөр), сонгон шалгаруулалтыг дараагийн нэг сарын хугацаанд хийн, шалгарсан төслүүдийн гэрээг 12 дугаар сарын 01- нээс 20-ний өдрийн дотор байгуулж, үргэлжлэх хугацааг санхүүгийн жилээр тооцно.

8.2. МУИС-иас санхүүжих судалгааны төсөл, тэтгэлэгт хөтөлбөрүүдийг холбогдох мэргэжлийн шинжээчдээс бүрдсэн сонгон шалгаруулах ажлын хэсгийг төслийн төрөл бүрээр ЭШХАХ дэд захирал байгуулж, сонгон шалгаруулалтыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/349 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Шинжээчийн жагсаалт шинэчлэн батлах тухай"

журмын дагуу явуулна. Сонгон шалгаруулалтыг төсөл хүлээн авсан эцсийн хугацаанаас хойш гурван долоо хоногийн дотор зохион байгуулна.



8.3. Өндөр түвшний судалгааны төсөл болон залуу судлаачдын судалгааны тэтгэлгийн санхүүжилтийг шинээр эхлэх судалгаанд биш, тодорхой түвшинд хүртэл хийгдээд, анхдагч үр дүн гарсан судалгааны ажлыг дэмжих чиглэлд зарцуулахыг илүүд үзнэ.

8.4. Профессор, дэд профессор багш нар өндөр түвшний судалгааны төсөл, залуу судлаачдын багийн тэтгэлэг, өртөг хуваалцах төсөлд удирдагч, эсвэл гүйцэтгэгчээр жилд нэг төсөлд нэг л удаа оролцоно.


8.5. Бүх төрлийн төслийн санхүүжилтийн гэрээг ЭШХАХ дэд захирал, Санхүү, төлөвлөлт хариуцсан (СТХ) дэд захиралтай хийнэ.

8.6. Судалгааны төсөл, тэтгэлэгийн удирдагч нь судалгааны гүйцэтгэл ба санхүүгийн зарцуулалтаа улирлаар ТММС-д оруулна. Эрдэм шинжилгээний хэлтэс (ЭШХ), Санхүү, төлөвлөлтийн газар (СТГ) хагас жилээр системийн өгөгдлийг хянаж баталгаажуулна. Судалгааны төсөл, тэтгэлэгийн удирдагч нь эцсийн тайлангаа салбарын эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлсний үндсэн дээр ТММС-д эцсийн судалгааны тайлан, санхүүгийн тайлан, үр дүнгийн баталгаажуулалтаа 12 дугаар сарын 25-ны дотор оруулна. ЭШХ нь салбарын эрдмийн зөвлөлийн протокол, үр дүнгийн баталгаажуулалт, тайланг хянан магадлан төслийг хаана.

8.7. Үр дүнгээ хугацаандаа тайлагнаагүй, гэрээнд тусгасан ажлын үр дүнг биелүүлээгүй төслийн удирдагч болон профессор, багш нарын төслийн эцсийн хугацааг салбарын эрдмийн зөвлөлийн шийдвэрийг үндэслэн 3-12 сараар сунгаж болно. Сунгалтын хугацаа дуусгавар болоход тайлангаа ирүүлээгүй тохиолдолд дахин төслийн санхүүжилт олгохгүй. Түүнчлэн санхүүгийн болон судалгааны тайлангаа ирүүлээгүй багшид дахин МУИС-ийн судалгааны санхүүжилт олгохгүй, профессор, дэд профессорын зэрэг, цолны сонгон шалгаруулалтаас оноо хасах

зарчмыг баримтална.

8.8.Төслийн гүйцэтгэлийн явц санхүүжүүлэгчээс үл хамаарах шалтгаанаар удаашрах, үр дүн нь гэрээнд заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд ЭШХ-ийн зүгээс хугацаанаас нь өмнө гэрээг цуцлах, санхүүжүүлсэн хөрөнгийг гүйцэтгэгчээр нөхөн төлүүлэх талаар ЭШХАХ дэд захирал, СТХ дэд захиралд санал тавьж шийдвэрлүүлнэ.



ЁС. ТӨСЛИЙН ҮР ДҮНГ ТҮГЭЭХ

9.1 Бүх төрлийн төсөл, тэтгэлгийн судалгааны үр дүнгийн тайлан, өгүүлэл хэвлүүлсэн сэтгүүлийн мэдээллийг Эрдэм шинжилгээний мэдээллийн менежментийн систем (ЭШММС)-д оруулна.

9.2 Гүйцэтгэгч төслийн үр дүнг хэвлэн нийтлүүлэх, эрдэм шинжилгээний хуралд илтгэх, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, интернетээр мэдээлж түгээх, сурталчлахдаа МУИС-ийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн төслийн хүрээнд гүйцэтгэсэн болохыг заавал дурьдана.

ПРОФЕССОР, ДЭД ПРОФЕССОРЫН
СУДАЛГААНЫ СУУРЬ ЗАРДЛЫН КАРТ



1	Профессор/дэд профессор, докторын зэрэгтэй ахлах багшийн нэр, эрдмийн зэрэг цол, докторын зэрэг хүртсэн он, харьяалал	
2	Судалгааны чиглэл	
3	Судалгааны суурь зардлын зарцуулалтын санал (тодорхой бичиж, хавсаргах)	
4	Хүлээгдэх үр дүн	

Профессор, дэд профессор, багшийн гарын үсэг:

Холбогдох утас/имэйл хаяг:




ЗАЛУУ СУДЛААЧДЫН БАГИЙН ТЭТГЭЛГИЙН КАРТ

1	Судалгааны төслийн сэдэв	
2	Удирдагчийн нэр, эрдмийн зэрэг цол, харьяалал	
3	Гүйцэтгэгчдийн нэрс, эрдмийн зэрэг цол, харьяалал	
4	Судалгааны төсөл нь журамд дурдсан шаардлагыг хэрхэн хангаж байгаа талаар тодорхой бичиж хавсаргах	
5	Нийт судалгааны зардлын зарцуулалтын төлөвлөгөө	
6	Ажлын календарьчилсан төлөвлөгөө	
7	Судалгааны ажлын хүлээгдэх үр дүн (Олон улсын импакт фактор бүхий сэтгүүлд хэвлүүлэх өгүүлэл, авах патент гэх мэт тодорхой бичих)	

Удирдагчийн гарын үсэг:
Холбогдох утас/имэйл хаяг:

ЗОЧИН СУДЛААЧ, ДОКТОРЫН ДАРААХ СУДАЛГААНЫ
ТЭТГЭЛЭГ (FELLOWSHIP)-ИЙН КАРТ



1	Төслийн сэдэв	
2	Зочин/докторын дараах судлаачийн нэр, эрдмийн зэрэг цол, харьяалал	
3	Зочин/докторын дараах судлаачтай хамтран ажиллах МУИС-ийн профессор багшийн нэр, эрдмийн зэрэг цол, харьяалал	
4	Зочин/докторын дараах судлаач, түүнтэй хамтран ажиллах МУИС-ийн профессор багшийн судалгааны ажлын туршлага (Сүүлийн 5 жилд олон улсын импакт фактор бүхий сэтгүүлд хэвлүүлсэн, мэдүүлсэн болон эрхийн хамгаалалт хийгдсэн оюуны өмч зэрэг бүтээлийн жагсаалтыг хавсаргах)	
5	Судалгааны ажлын төсөв, түүний задаргаа	
6	МУИС-д ирж ажиллах хугацаа (нотлох баримтыг хавсаргах)	
7	МУИС-д ажиллах үндэслэл, шаардлага, судалгааны ажлын ач холбогдол	
8	МУИС-д ирж ажиллах ажлын календарчилсан төлөвлөгөө (судалгааны ажил, хэлэлцүүлэх болон удирдан явуулах семинар гэх мэт)	
9	Судалгааны хамтын ажиллагаа цаашид тогтвортой үргэлжлэх нотолгоо	
Үр дүнгийн нөлөө, үр ашиг		
10	Төслийн үр дүнгийн эдийн засаг/ эдийн засгийн бус үр ашиг	
11	Төслийн хэрэгжилтэд саад болж болзошгүй эрсдэл, хүчин зүйл	

Төслийн удирдагчийн гарын үсэг:

Холбогдох утас/имэйл хаяг:



ӨНДӨР ТҮВШНИЙ СУДАЛГААНЫ ТӨСЛИЙН САНАЛЫН КАРТ

1	Төслийн сэдэв	
2	Төслийн нийт төсөв	
3	Төслийн удирдагчийн нэр, эрдмийн зэрэг цол, харьяалал	
4	Төслийн гүйцэтгэгчдийн нэрс, эрдмийн зэрэг цол, харьяалал (сүүлийн 5 жилд олон улсын импакт фактор бүхий сэтгүүлд хэвлүүлсэн, мэдүүлсэн болон эрхийн хамгаалалт хийгдсэн оюуны өмч зэрэг бүтээлийн жагсаалтыг хавсаргах)	
5	Энэ төслийг хэрэгжүүлэх үндэслэл, шаардлага, ач холбогдол	
6	Төслийн хүлээгдэх үр дүн, үр дүнгийн баталгаа (Олон улсын импакт фактор бүхий сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх, МУИС-ийн нэр дээр оюуны өмч мэдүүлэх эсэх талаар тодорхой бичих)	
7	Төслийн зардлын зарцуулалтын төлөвлөгөө	
8	Ажлын календарьчилсан төлөвлөгөө (сараар)	
Үр дүнгийн нөлөө, үр ашиг		
9	Төслийн үр дүнгийн эдийн засаг/ эдийн засгийн бус үр ашиг	
10	Төслийн хэрэгжилтэд саад болж болзошгүй эрсдэл, хүчин зүйл	

Төслийн удирдагчийн гарын үсэг:

Холбогдох утас/имэйл хаяг:

Хүснэгт 5.


1117144746
УХД0072 9104399

СУДАЛГААНЫ ӨРТӨГ ХУВААЛЦАХ ЗАРДЛЫН КАРТ

1	Төслийн сэдэв	
2	Төслийн удирдагчийн нэр, эрдмийн зэрэг цол, харьяалал	
3	Төслийн шаардлагатай төсөв, түүний задаргаа (өртөг хуваалцах)	
4	Санхүүжүүлэгч байгууллага, гадаадын их сургуульд өгөх төслийн санхүүжилтийн хэмжээ	
5	Санхүүжүүлэгч байгууллага, олон улсын судлаачид, гадаадын их сургууль, аж ахуйн нэгж байгууллагаас хамтарсан төсөлд оролцож, хамтран гүйцэтгэх сонирхлоо илэрхийлсэн байдал (нотлох баримтыг хавсаргах)	
6	Төслийн гүйцэтгэгчдийн нэрс, эрдмийн зэрэг цол, харьяалал (Сүүлийн 5 жилд олон улсын импакт фактор бүхий сэтгүүлд хэвлүүлсэн, мэдүүлсэн болон эрхийн хамгаалалт хийгдсэн оюуны өмч зэрэг бүтээлийн жагсаалтыг хавсаргах)	
7	Энэ төслийн саналыг боловсруулах үндэслэл, шаардлага, ач холбогдол	
8	Санхүүжилт, хөрөнгө оруулалт авах боломжийн нотолгоо (багийн гишүүдийн олон улсын төслийн санхүүжилт, хөрөнгө оруулалт авч байсан туршлага, санхүүжүүлэгч байгууллагын санхүүжилтийн бодлоготой нийцсэн байдал, грант зарласан байгууллагаас төслийн саналыг санхүүжүүлсэн санхүүжилтийн хувь гэх мэт)	
9	Ажлын календарьчилсан төлөвлөгөө (сараар)	
Үр дүнгийн нөлөө, үр ашиг		
10	Төслийн үр дүнгийн эдийн засаг/ эдийн засгийн бус үр ашиг	
11	Төслийн хэрэгжилтэд саад болж болзошгүй эрсдэл, хүчин зүйл	

Төслийн удирдагчийн гарын үсэг:

Холбогдох утас/имэйл хаяг:



ИННОВАЦИЙН ТӨСЛИЙН САНАЛ БОЛОВСРУУЛАХ КАРТ

1	Төслийн сэдэв	
2	Төслийн удирдагчийн нэр, эрдмийн зэрэг цол, харьяалал	
3	Энэ төслийн саналыг боловсруулах үндэслэл, шаардлага, ач холбогдол	
4	Төслийг аж үйлдвэр болон бизнесийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх тохиолдолд хамтрагч байгууллагаас дэмжлэг үзүүлэх хэлбэр болон хамтран ажиллах зарчмыг тодорхойлсон гэрээ	
5	Төслийн санал боловсруулахад шаардлагатай төсөв, түүний задаргаа	
6	Төслийн гүйцэтгэгчдийн нэрс, эрдмийн зэрэг цол, харьяалал (Мэдүүлсэн болон эрхийн хамгаалалт хийгдсэн оюуны өмч, сүүлийн 5 жилд олон улсын импакт фактор бүхий сэтгүүлд хэвлүүлсэн бүтээлийн жагсаалтыг хавсаргах)	
7	Төсөл тогтвортой, амжилттай хэрэгжих боломжийг илэрхийлсэн тайлбар - Тухайн салбарын тулгамдсан асуудлыг шийдвэрлэсэн эсэх /Зах зээл дээр үйлчилгээний давуу байдлыг бий болгосон байдал - Шинжлэх ухааны багтаамж, мэдлэг шингэсэн давуу байдал - Нийгэм, эдийн засгийн үр ашгийн тооцоолол - Зах зээлд тогтвортой байрших судалгаа хийгдсэн эсэх - Импортыг орлосон, экспортод чиглэсэн эсэх / Тухайн салбарт үйлчилж буй шинэлэг байдал	
8	Ажлын календарьчилсан төлөвлөгөө (сараар болон жилээр)	
9	Бусад	
Төслийн хүлээгдэж буй үр дүн		
10	Төслийн үр дүнд бий болох: - Гарааны компани байгуулах - Технологийн лицензийн гэрээ байгуулах - Нийгмийн инновацийн шийдэл	
11	Төсөл хэрэгжүүлэх бизнес төлөвлөгөө	
12	Төслийн үр дүнгийн тооцоолол	
13	Эрсдэл, хүчин зүйл, түүний шийдэл	

Төслийн удирдагчийн гарын үсэг:

Холбогдох утас/имэйл хаяг:

Захирлын 2018 оны ...дугаар сарын.....-ны

өдрийн... дугаар тушаалын 2 дугаар хавсралт

2019 онд мөрдөх судалгааны санхүүжилтийн хэмжээ

Д/Д	Судалгааны баг, ажлын төрөл	Хэнд олгох	Олгох мөнгөний дэд хэмжээ (мян.төгрөг)
1	Судалгааны суурь зардал	Профессорын зэрэглэлд ажиллаж байгаа багшид (судалгааны лабораторийн удирдагч бус)	2,000.0 (хоёр сая)
		Дэд профессорын зэрэглэлд ажиллаж байгаа багшид (судалгааны лабораторийн удирдагч бус)	1,000.0 (нэг сая)
		Ахлах багшийн зэрэглэлд ажиллаж байгаа багшид (докторын зэрэгтэй багшид)	1,000.0 (нэг сая)
		Профессорын зэрэглэлд ажиллаж байгаа судалгааны лабораторийн удирдагч багшид	3,000.0 (гурван сая)
		Дэд профессорын зэрэглэлд ажиллаж байгаа судалгааны лабораторийн удирдагч багшид	2,000.0 (хоёр сая)
2	Залуу судлаачдын багийн тэтгэлэг	Салбар дундын багт олгох	10,000.0 (арван сая)
3	Зочин судлаачийн тэтгэлэг Докторын дараах судалгаа	Судалгааны чиглэлээс хамаарч олгох	60,000.0 (жаран сая)
			20,000.0 (хорин сая)
4	Өндөр түвшний судалгаа	Нэг төсөлд олгох	30,000.0 (гучин сая)
5	Өртөг хуваалцах хамтарсан төсөл	Нэг төсөлд нийт төсвийн 30 % хүртэл санхүүжилт	100,000.0 (зуун сая)
6	Инновацийн төсөл	Нийт инновацийн төслүүдийн санхүүжилтийн хэмжээ	100,000.0 (зуун сая)